

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2021 оны жилийн эцсийн байдлаар тайлагнав)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2022-01-16

Улаанбаатар хот

ЗГҮАХ-г тусгагдсан зорилт (зорилтын дугаар)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ (арга хэмжээний дугаар)	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)	
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.

3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ (арга хэмжээний дугаар)	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	ТӨБЗГ – ТӨУЗХ
	5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын байгуулах хүрээнд баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	2020-2024	УУХУЯ, "ЭУ" ТӨҮГ, ТӨБЗГ	14,222.2	ТЭЗҮ-ийн тодотгол хийх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. 123,446.0 сая төг.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр (МХУ) байгуулах ТЭЗҮ-ийг БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай хамтран боловсруулж, 2020 оны 9 дүгээр сард ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хүлээн авсан. Ингэснээр МХУ-ийн үндсэн ТЭЗҮ 100 хувь бэлэн болсон. Хүхрийн давхар исэл агуулсан хийг боловсруулах доорх 2 хувилбарыг нарийвчлан судлах ажил хийгдэж байна. Үүнд: 1.МХУ-ээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг боловсруулан элементийн хүхэр ялган авах үйлдвэрийн "үйлдвэрлэлийн туршилт" 50%: МХУ-ийн хийг боловсруулан элементийн хүхэр үйлдвэрлэх технологийг үйлдвэрлэлд

						<p>нэвтрүүлэх боломжийг тодорхойлох үйлдвэрлэлийн туршилтын ажлыг China ENFI Engineering компанитай хамтран эхлүүлээд байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 2021 онд 4,992,000.0 ам.доллар буюу 14,222,208,000.0 төгрөгийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн.</p> <p>МХҮ-ээс гарах хүхрийн хүчлээр фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааны ажил 45%: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2021.02.17-ны өдрийн А/80 дугаар тушаалаар "Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгаа"-ны ажлыг хийж гүйцэтгэх Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Энэ ажлын тендерийг 5 удаа зарласны эцэст Шинжлэх ухааны академийн харьяа "Хими, химийн технологийн хүрээлэн" шалгарч, 2021.08.17-ны өдрөөс гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу Судалгаа, шинжилгээний хүрээлэн дээр Бүрэнхааны фосфоритын ордын хүдрийг баяжуулан 60 орчим кг фосфоритын баяжмал (P2O5-30-32%) үйлдвэрлэж, Хими, химийн технологийн хүрээлэнд 2021 оны 9 сарын 27-ны өдөр хүргүүлсэн. Баяжмал хүлээн авсан тухай болон ажлын явцын эхний цахим тайланг 2021.10.29-ний өдөр, гэрээт ажлын явцын талаарх 4 дэх мэдээллийг 2021.12.10-ны өдөр хүрээлэнгээс тус тус ирүүлсэн. Гүйцэтгэгч гэрээт ажлыг 2022 оны 2 дугаар сард хүлээлтэн өгнө. Гэрээтэй холбоотой зардал 2021 онд гараагүй.</p> <p>Өөрийн үнэлгээ: 90 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор бэлтгэл, боловсруулалт, зохион байгуулалтын ажлууд хийгдсэн. Туршилт судалгааны ажлууд хийгдэж, үр дүн гарч эхэлж байгаа. Туршилтын ажилд тайлант онд 14,222.2 сая төгрөг зарцуулсан байна.</p>
6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын УТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЭГ	2020-2022	745.3	Үйлдвэр, Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, тусгай	<p>ТӨБЭГ – ТӨУЗХ</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" УТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах асуудлыг Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 129 дүгээр тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-г "Үйлдвэрлэл, технологийн паркийн</p>	

					<p>зөвшөөрөл авах. 50%</p> <p>83,685.5 сая төг.</p>	<p>үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хооронд 2021.06.22-ны өдөр 5/159-21 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Уул уурхай металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг 2021.07.01-ний өдөр Орхон аймгийн ИТХ-аар хэлэлцэн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшигч буй 871.4 га, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрээс 175.4 га, Жаргалант сумын нутаг дэвсгэрээс 170.6 га, нийт 1,217.4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжиж, 14 дүгээр тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т олгосон.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Катодын зэсийн үйлдвэр (КЗУ)-ийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажил тусгагдсан.</p> <p>Техникийн зөвлөлийн 2021.03.30-ны өдрийн хурлаас "Жилд 10,000 тн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн ТЗЗУ болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах" ажлыг хийж гүйцэтгэх шийдвэр гаргасан. Зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирлын нэгдүгээр орлогч бөгөөд Ерөнхий инженерээр 2021.04.06-ны өдөр батлуулсан. Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирлын 2021.04.15-ны өдрийн А/185 дугаар тушаалаар байгуулагдсан КЗУ-ийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэлийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь тендерийг 2021.04.23-ны өдрөөс эхлэн 2 дахин зарласны эцэст "Майнин шорт лонг терм" ХХК шалгарч, 2021.09.17-ны өдөр 6/006-21 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. Тус компанийн ажилд хяналт тавьж, хамтран ажиллах ажлын хэсгийг Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирлын 2021.11.11-ний өдрийн А/585 тушаалаар байгуулсан. 2021.11.12-ны өдөр ажлын явцын хурлыг зохион байгуулсан. Гэрээний дагуу Гүйцэтгэгч компани 2022 оны 4 дүгээр сард ажлыг дуусган хүлээлгэж өгнө.</p> <p>"Майнин шорт лонг терм" ХХК-д "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас 2021.12.15-ны өдөр 745,342,275.0 төгрөг буюу 261,615.4 ам.долларын урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байна.</p>
--	--	--	--	--	---	---

						<p>Өөрийн үнэлгээ: 70 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор бодлого, төлөвлөлтийн ажлыг хийсэн. Зорилт, арга хэмжээний хэрэгжилт, түүний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг хангах зорилгоор бэлтгэл, боловсруулалтын шатны ажил хийгдсэн. КЗУ-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах гүйцэтгэгч шалгарч, гэрээ байгуулсан, ажил тодорхой хэмжээнд хийгдсэн. Гэрээний дагуу гүйцэтгэгчийн ажил 2022 оны 4 дүгээр сард дуусна.</p>
<p>3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.</p> <p>3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулал-таар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.</p>	<p>1. Үндэсний орон сууцны корпораци байгуулах эрх зүйн бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.</p>	<p>2020-2024</p>	<p>БХБЯ, ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж, төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ХХК байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан.</p> <p>Уг тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд болон “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн төлөөлөл оролцсон бүрэлдэхүүн 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн болон бусад холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар ярилцсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А-1/534 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт уг асуудлаар хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлсэн.</p> <p>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг татан</p>

						<p>буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн байна. Гэвч өнөөдрийг хүртэл ямар нэгэн шийдвэр гараагүй.</p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэх, зохих шийдвэр гаргах боломжтой.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор ТӨБЗГазар нь холбогдох судалгааг хийж, Ерөнхий сайд, ЗГХЭГазар, БХБЯамны сайдуудад танилцуулан, зөвшилцөж, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан. Энэхүү шийдвэрийн дагуу ТӨБЗГазраас холбогдох зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн.</p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргах шийдвэр хүлээгдэж байна.</p>
--	--	--	--	--	--	--

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1 "Цахим Монгол" - төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

<p>4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.</p>	<p>5. Төрийн орон өмчийн хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын</p>	<p>2021-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн байна.</p>	<p>ТӨБЗГ - ТӨБАХ, МТА</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгоход шаардагдах хөрөнгийн асуудлыг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгуулан шийдвэрлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч ажилласан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгоход шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн зардал шийдвэрлэгдэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдаж, Монгол Улсын төсвийн</p>
---	---	------------------	--------------	----------	---	--

	мэдээллийн системтэй холбоно.					<p>хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад холбогдох төсөл, арга хэмжээ тусгагдсан.</p> <p>Уг төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2021 оны А/31 дүгээр тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж, шаардлагатай суурь судалгаа, мэдээллийг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийсэн байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлж, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд 1,200.0 сая төгрөг тусгуулсан. Тус ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, судалгааны ажил хийгдсэн үр дүнтэй.</p>
<p>4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.</p> <p>4.2.4.Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.</p>	<p>1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.</p>	2021-2024	ТӨБЭГ	-	<p>Хууль эрх зүйн орчин, чиг үүрэг тодорхой болсон байна.</p>	<p>ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусын асуудлыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудал тусгагдсан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн өмчийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх тухай зааж өгсөн. Түүнчлэн, Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь орон нутагт нэгжтэй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан нь өнөөгийн Орон нутгийн өмчийн газрыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах боломжийг бүрдүүлнэ гэж үзсэн. Энэ зарчим нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд батлагдах хууль тогтоомжид бүрэн тусгагдан хэрэгжих ёстой.</p> <p>Монгол улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 46 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалт "... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг Төрийн өмчийн корпораци болгож өөрчлөн зохион байгуулах асуудлыг судалж, холбогдох</p>

					<p>саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах..." гэж заасныг үндэслэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газрын засаглал, ашигт ажиллагаа, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, өгөөжийг нэмэгдүүлэх, нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох саналыг боловсруулан ЗГ-ын ХЗГ-т 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-1/1688 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагын чадавхи, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлыг боловсруулах хүрээнд төрийн өмчийн удирдлага, менежмент болон гадаадын улс орнуудын төрийн өмчийн талаархи бодлого, баримталж буй чиглэл, компанийн засаглал, санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх OECD, PWC, ADB (АХБ), World Bank, IDB, IMF (ОУВС), EBRD зэрэг олон улсын байгууллагын туршлага, судалгааны үр дүн, тайланг судалж, холбогдох санал, загварыг боловсруулсан.</p> <p>Түүнчлэн, Компанийн засаглалын олон улсын туршлага, Төрийн өмчийн баялгийн сан, корпорацийн засаглал, үйл ажиллагааны бүтцийг Казакстаны САМРУК КАЗИНА, БНХАУ-ын SASAC, Сингапур улсын ТЭМАСЕК Холдинг зэрэг корпорациудын засаглал, үйл ажиллагааны бүтэц, өмчлөлийн байдал, Fortune Global 500 буюу дэлхийн шилдэг 500 компанийн жагсаалт зэргийг судалж, холбогдох танилцуулга, материалыг бэлтгэн Ерөнхий сайд, Ерөнхий сайдын ахлах зөвлөхөд танилцуулсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: 90 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор ТӨБЗГ нь өөрөөс хамаарах ажлыг гүйцэтгэсэн.</p>
<p>2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт,</p>	<p>2020-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>25 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн байна.</p>	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>Төрийн өмчийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 25 хуулийн этгээд (төрийн өмчит компани, үйлдвэрийн газар)-д баримтын иж бүрэн хяналт шалгалт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тайлант жилд нийт 27 хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.</p>

	<p>хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.</p>		<p>Үүнээс төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус 6, гүйцэтгэлийн 10 хяналт шалгалт, нийт 27 хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.</p> <p>1.Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн: Төрийн өмчит 11 хуулийн этгээдэд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаас 10 шалгалтын дүн, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулсан, 1 шалгалтын тайланг баталгаажуулахаар бэлтгэж байна.</p> <p>Төлөвлөгөөт хяналт шалгалтын тайлангийн баталгаажсан дүнгээр 12.490.74 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчил арилгах асуудалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх нийт 90 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах 86 арга хэмжээ бүхий үүрэг даалгаврыг эрх бүхий албан хаагчдад хүргүүлэн, 69 ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.</p> <p>Зөрчлийн төрөл (нийт зөрчилд эзлэх хувиар):</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зөрчсөн - 3.27 хувь; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн - 53.22 хувь; - Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн - 7.26 хувь; - Компанийн тухай хуулийг зөрчсөн - 6.23 хувь; - Төсвийн тухай хуулийн зөрчил - 20.8 хувь; - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зөрчил - 0.26 хувь; - Засгийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийг зөрчсөн - 5.18 хувь; - бусад хууль тогтоомжийн зөрчил - 3.76 хувь. <p>2.Төлөвлөгөөт бус хяналт шалгалт: Засгийн газар, Сангийн сайд, 2020 оны 48-р тэмдэглэл, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга, зарим салбарын сайд, ТӨБЗГ-ын даргын удирдамж, үүрэг даалгаврын дагуу нийт төрийн өмчит 6 хуулийн этгээдэд төлөвлөгөөт бус баримтын шалгалт хийж, дүн, тайланг тухайн ажлын хэсгийн нэгдсэн тайланд нэгтгүүлэн, холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан. Төлөвлөгөөт бус баримтын шалгалтад хамрагдсан төрийн</p>
--	--	--	--

						<p>өмчит 6 хуулийн этгээдэд нийт дүнгээр 290.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.</p> <p>3.Гүйцэтгэлийн хяналт шалгалт: Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоол шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн хяналт шалгалтад төрийн өмчит 10 хуулийн этгээдийг хамруулав.</p> <p>Хяналт шалгалтын дүнгээр төрийн өмчит 6 хуулийн этгээдэд Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 3 албан хаагчид хариуцлага тооцуулах арга хэмжээ авсан байна.</p> <p>Шалгалтын үр дүнгээр зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч байгаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал сайжирсан бөгөөд 2020-2021 онд улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн төрийн өмчийн түрээсийн орлого болох 189.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 %</p> <p>Тэмдэглэл: Тайлант онд дэвшүүлсэн зорилгот түвшиндээ хүрч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 27 хуулийн этгээд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын тайлангийн баталгаажсан дүнгээр 12.490.74 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгах асуудалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх нийт 90 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах 86 арга хэмжээ бүхий үүрэг даалгаврыг эрх бүхий албан хаагчдад хүргүүлэн, 69 ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.</p>
<p>3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.</p>		2020-2024	ТӨБЗГ	-	10 төсөвт байгууллагад шалгалт хийсэн байна.	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>Төрийн өмчийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 11 төсөвт байгууллагад системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтад хяналт тавьсан байна. Хяналт шалгалтын баталгаажсан дүнгээр төсөвт 9 хуулийн этгээдэд нийт 1,268.12 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, баталгаажуулсан дүнгийн мөрөөр цаашид авч</p>

						<p>хэрэгжүүлэх нийт 53 арга хэмжээ, 55 зөвлөмжийг шалгалтад хамрагдсан байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, 35 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан бөгөөд шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тогтоол, тайланг тухайн байгууллага болон салбарын яаманд нь хүргүүлсэн.</p> <p>Улсын төсөвт 2 байгууллагад хийсэн шалгалтын дүн, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан баталгаажуулж, шийдвэр гаргуулахаар хүлээгдэж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 11 төсөвт байгууллагад системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, 9 хуулийн этгээдэд нийт 1,268.12 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна.</p>
<p>4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн</p>	<p>1.Төрийн орон нутгийн болон өмчийн тухай, Төрийн өмчийн төрийн оролцоотой хуулийн этгээдийн тухай боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p>	<p>2020-2023</p>	<p>ХЗДХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)</p>	<p>-</p>	<p>Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. 20.0 сая төг.</p>	<p>ТӨБЗГ – ХЗХХ</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх энэ арга хэмжээ УИХ-ын 2020 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 4.1.19-т тусгагдан батлагдсан.</p> <p>1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг ЗГХЭГ хариуцан ажиллаж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурал 2 удаа зохион байгуулагдаж, хуулийн төслийг хэлэлцсэн.</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд засвар оруулан найруулсан төслийг хүлээн авч, Ажлын хэсгийн</p>

байгууламж нэгдмэл байх зарчим бслон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.					<p>саналыг судлан боловсруулах, төсөлд тусгах арга хэмжээ авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/1951 тоот албан бичгээр хариу хүргүүлэв.</p> <p>2.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөлд санал авахаар дараах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хуулийн төсөлтэй танилцан судалж, холбогдох санал боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан бичгээр тус тус хүргүүлэв:</p> <ul style="list-style-type: none"> - 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-1/939 тоот албан бичгээр ЗГХЭГ-т; - 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн 1/1833 тоот албан бичгээр. <p><u>Өөрийн үнэлгээ: 90 %</u></p> <p><u>Тэмдэглэл:</u> Тайлант онд тавьсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ нь өөрсдөөс хамаарах ажлыг боловсруулан дээд шатны байгууллагад өргөн барьсан хамтран хэрэгжүүлэгч байгууллагаас шалтгаалан үр дүн хүлээгдэж байна.</p>
2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гаргах дүрэм, журмыг боловсруулж, батална.	2021-2023	ТӨБЗГ	Холбогдох судалгаа хийж, дүрэм, журмын төслүүдийг боловсруулсан байна.	<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт буюу хууль санаачлагчид хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд дагалдан гарах 13 дүрэм, журам батлагдана гэж төлөвлөж байгаа бөгөөд үүнээс 9-ийг нь Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас, 4-ийг Засгийн газраас тус тус батлахаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 4.1.19-т Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьж батлуулах, дагалдан гарах 3 журмын төслийг боловсруулан баталж мөрдүүлэх тухай зорилт, арга хэмжээ тусгагдан батлагдсан.</p>	

						<p>ТӨБЗГ-ын зүгээс дээр дурдсан холбогдох журам, дүрмийн төслийг боловсруулан бэлтгэсэн бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдахтай уялдан албажна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ: 90 %</u></p> <p><u>Тэмдэглэл:</u> Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГазрын хариуцан батлах 9 дүрэм, журмын төслийг боловсруулж бэлтгэсэн.</p>
<p>3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.</p>	<p>2021-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>Компанийн засаглалын олон улсын туршлагыг судалсан байна.</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Компанийн засаглалын олон улсын туршлага, сайн жишгийг судлах чиглэлээр Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь төлөөлөгчтэй уулзалт хийж, зөвлөмж, арга зүйн зөвлөгөө авч, холбогдох судалгаа мэдээллийг хүргүүлэн хамтран ажилласан. Дэлхийн банкны техникийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийг боловсруулсан. Тус загвар төслийг компанийн засаглалын талаарх олон улсын сайн туршлагыг Монгол Улсын өнөөгийн нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэх байдлаар боловсруулсан ба зөвлөмжийн дагуу манай улс төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудыг төвлөрсөн, нэгдмэл удирдлагаар хангах байдлаар хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзэв.</p> <p>Компанийн засаглалын олон улсын туршлага, Төрийн өмчийн баялгийн сан, корпорацийн засаглал, үйл ажиллагааны бүтцийг Казакстаны САМРУК КАЗИНА, БНХАУ-ын SASAC, Сингапур улсын ТЭМАСЕК Холдинг зэрэг корпорациудын засаглал, үйл ажиллагааны бүтэц, өмчлөлийн байдал, Fortune global 500 буюу дэлхийн шилдэг 500 компанийн жагсаалт зэргийг судалж, холбогдох танилцуулга бэлтгэн удирдлагуудад танилцуулсан.</p> <p>Төрийн өмчийн удирдлага, менежмент болон олон улсуудын төрийн өмчийн талаарх бодлого, баримталж буй чиглэл, компанийн засаглал, санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх OECD, PWC, ADB (АХБ), World Bank, IDB, IMF (ОУВС), EBRD зэрэг олон улсын байгууллагуудаас эрхлэн гаргасан судалгаа, тайлантай танилцан судалж, боловсруулалт хийв.</p>	

						<p>Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү, эдийн засгийн их сургууль, "Компанийн засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран ажиллаж, "Монгол шуудан" ХК (73%), "Монголын цахилгаан холбоо" ХК (62%), "Монголын төмөр зам" ТӨХК (59%), "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК (60.5%), "Амгалан дулааны станц" ТӨХК (52.6%), "Хөдөө аж ахуйн бирж" ХХК (61.9%), "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК (84.6%) гэсэн нэр бүхий төрийн өмчит 7 компанийн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь байсан бол 64.8 хувьд хүрсэн үр дүнтэй байна.</p> <p>Мөн "Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, бие даасан байдлыг сайжруулах аргууд", "Төрийн өмчит компанид нэгдмэл тайлагналыг нэвтрүүлэх арга зам", "Төрийн өмчит компаниудын дотоод хяналтын тогтолцоог үнэлж, сайжруулах арга зам" зэрэг компанийн засаглалын шалгуур, шаардлагатай холбоотой тодорхой сэдвээр Санхүү, эдийн засгийн их сургууль болон "Компанийн засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран судалгаа хийсэн.</p> <p>Компанийн засаглалын асуудалтай холбоотойгоор төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тодорхой загвар байж болох, төр түүний хувьцааг эзэмшиж байгаагийн хувьд хувьцааг олж авах, захиран зарцуулах, хувьцаанд ногдох эрхийг хэрэгжүүлэх механизмыг зөв тогтоох, энэ агуулгаар төр хувьцааг тооцоо, судалгааны үндсэн дээр тодорхой салбарт эзэмших, хувьцаа эзэмшигчийн ямар эрхээ аль байгууллагаар дамжуулж хэрэгжүүлэх хуваарилалт, хариуцлагын эргэх холбоо, тайлагнал, ил тод байдлыг хангах механизмын талаар судлан холбогдох саналыг боловсруулж, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөлд тусгах арга хэмжээ авсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр Олон Улсын байгууллагуудаас зөвлөмж чиглэл авч, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр,</p>
--	--	--	--	--	--	---

						<p>засаглалыг сайжруулах загвар төслийг боловсруулсан. Компанийн засаглалын олон улсын туршлага, Төрийн өмчийн баялгийн сан, корпорацийн засаглал, үйл ажиллагааны бүтцийг Казакстаны САМРУК КАЗИНА, БНХАУ-ын SASAC, Сингапур улсын ТЭМАСЕК Холдинг зэрэг корпорациудын засаглал, үйл ажиллагааны бүтэц, өмчлөлийн байдал, Fortune Global 500 буюу дэлхийн шилдэг 500 компанийн жагсаалт зэргийг судалсан. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү, эдийн засгийн их сургууль, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж, нэр бүхий төрийн өмчит 7 компанийн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь байсан бол тайлант онд 64.8 хувьд хүрсэн үр дүнтэй байна.</p>
	<p>4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>2022-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 46 хуулийн этгээдийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. Тэдгээр төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани нь нийт дүнгээр, 2021 онд 3.0 их наяд төгрөгийн орлого олж, 2.5 их наяд төгрөгийн зардал гарган 381.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба мөн онд татвар хураамж хэлбэрээр 832.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх зорилт тавин ажилласан.</p> <p>2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дээр дурдсан төрийн өмчит хуулийн этгээдүүдийн орлого 4.0 их наяд төгрөг болж 30.0 хувиар, зардал 2.6 их наяд төгрөг буюу 6.6 хувиар, цэвэр ашиг 940.0 тэрбум болж 146.7 хувиар тус тус өссөн байна. Мөн 1.1 их наяд төгрөгийн татвар хураамж, төсвийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 39.3 хувиар өссөн үр дүнтэй байна.</p> <p>2021 оны төлөвлөгөөнд өглөгийг 3.6 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 3.2 их наяд төгрөг болж 9.6 хувиар, авлагыг 1.4 их наяд төгрөг байхаар</p>	

						<p>төлөвлөсөн нь 506.0 тэрбум төгрөг болж 64.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд төрийн өмчит компани, үйлдвэрийн газрыг хэмнэлтийн горимд шилжүүлж ажиллах асуудлаар ТӨБЗГ-аас төрийн өмчит 106 компани, үйлдвэрийн газарт албан даалгавар хүргүүлж, хяналт тавин ажиллав. ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа төрийн өмчит 46 компани, үйлдвэрийн газрууд хэмнэлтийн горимд ажилласнаар дараах хэмнэлт, үр дүнг гаргасан байна:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт цалингийн санг 13.2 тэрбум төгрөгөөр буюу 3.01 хувиар (Бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулж, 313 хүний цалингийн санг хэмнэж ажилласан); • Шагнал урамшууллын зардлыг 1.0 тэрбум төгрөгөөр хэмнэсэн; • Хөрөнгө оруулалтын зардлыг 454.5 тэрбум төгрөгөөр буюу 44.13 хувиар бууруулсан; • 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр борлуулалтын 1 төгрөг ногдох зардал 0.67 төгрөг болж, 2021 оны төлөвлөгөө 0.82 төгрөгөөс 0.15 төгрөгөөр буюу 18.14 хувиар буурсан үзүүлэлттэй байна. <p>Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу 2021 онд төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд 2020 оны цөвэр ашгаас төрийн өмчийн ногдол ашиг хэлбэрээр нийт 183.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс ашигтай ажилласан төрийн өмчит хуулийн этгээдээс 209.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээ 2022 оноос хэрэгжиж эхэлнэ. ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа төрийн өмчит 46 компани, үйлдвэрийн газрууд хэмнэлтийн горимд ажилласнаар 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр борлуулалтын 1 төгрөг ногдох зардал 0.67 төгрөг болж, 2021 оны төлөвлөгөө 0.82</p>
--	--	--	--	--	--	---

						<p>тегсгээс 0.15 тегсгээр буюу 18.14 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд 209.3 тэрбум тегсгийг улсын төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 115 хувиар давуулан биелүүлсэн.</p>
<p>5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.</p>	<p>2021-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>Улсын тооллого зохион байгуулсан байна.</p>	<p>ТӨБЗГ – ТӨБАХ</p> <p>Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2020 онд явуулахаар шийдвэрлэсэн боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас Засгийн газрын 2020 оны 46, 2021 оны 278 дугаар тогтоолоор 2 удаа хойшлуулж, 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Улсын үзлэг, тооллогыг зохион байгуулахтай холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан. Ингэснээр Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 4.4.1-д төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийх, хяналт тавих тухай асуудал тусгагдсан.</p> <p>Улмаар төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулахад шаардагдах төсөв Монгол Улсын 2022 оны төсөвт тусгагдан батлагдсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, улсын үзлэг, тооллогын ажлыг цар тахлын нөхцөл байдалд тохируулан зохион байгуулах боломж бүрдсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: 100 %</p> <p>Тэмдэглэл: Тавьсан зорилт, арга хэмжээнд шаардлагатай 358.3 сая тегсгийг санхүүжилтийг Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгуулсан. Цар тахлын нөхцөл байдлын улмаас Засгийн газрын 2020 оны 46, 2021 оны 278 дугаар тогтоолоор 2 удаа хойшлуулж, 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.</p>	

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг ТӨБЗГ-т хяналтад авч, хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргав.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 12 арга хэмжээний 11 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээ (4.4.10.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар үүрэг хүлээсэн болно.

Үнэлгээний дүнг тооцохдоо Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2 болон 6.2.3-т заасан аргачлалыг хэрэглэсэн болно. Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрч, үр дүнтэй хэрэгжсэн арга хэмжээг 100.0 хувиар үнэлж тооцсон.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 12; Үүнээс:

- 100 %-ийн хэрэгжилттэй – 6 арга хэмжээ;
- 90 %-ийн хэрэгжилттэй – 4 арга хэмжээ;
- 70 %-ийн хэрэгжилттэй – 2 арга хэмжээ;
- 50 %-ийн хэрэгжилттэй – 0;
- 30 %-ийн хэрэгжилттэй – 0;
- 0 % - 0.

ЗГҮАХХАХТ-ний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ – 91.7% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙНӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ДЭД ДАРГА

А.АРИУНБОЛД

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД



ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ



Хяналт-шинжилгээ, үнэлгээний
тайлангийн 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2021 оны жилийн эцэс		Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин			
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
4.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.								
106 (1)	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, захиран зарцуулалтад хийсэн хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо	Хуулийн этгээдийн тоо	26	35	38	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
107 (2)	Төрийн өмчийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн бууралт	хувь	3 хувь	5 хувь	10 хувь	2020 оны суурь түвшин, Өмнөх жилтэй харьцуулсан хувь	Жилд хоёр удаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
108 (3)	Төрийн өмчит компанийн засаглалын дундаж үнэлгээ	хувь	53.9	65.0	64.8	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР